

Монгол хэл зүйн бүтээл дэх хэл шинжлэлийн нэр томъёоны шинжилгээ

Энхжаргалын УРАНБИЛЭГ* ✉

БНХАУ, Өвөр Монголын их сургуулийн Монгол судлалын дээд сургууль

ДАВХАРБАЯР**

БНХАУ, Өвөр Монголын их сургуулийн Монгол судлалын дээд сургууль

Received: Oct 27, 2023

Revised: Nov 22, 2023

Accepted: Dec 11, 2023

Хураангуй: Монгол хэл шинжлэлийн судалгаа үүсэн хөгжихтэй зэрэгцэн монгол хэлний үзэгдлийг заан нэрлэсэн нэр томъёо бий болсоор иржээ. Хэл шинжлэлийн ерөнхий онол, сургаалыг судалгааны үндэс, аргаа болгож, монгол хэлний олон янзын үзэгдлийг тал бүрээс нь шинжлэн туурвисан хэл зүйн бүтээл, эрдэм шинжилгээний ном зохиол, сурах бичиг олон буй. Тэдгээр бүтээлд буй нэр томъёоны бүтэц, хэлбэр, утга, хэрэглээг тодруулан судлах нь хэлний тухай шинжлэх ухааныг судлан шинжлэх, заан сургах, бүтээл туурвих зэрэгт чухал ач холбогдолтой билээ.

Бидний өгүүлэлд голчлон хэрэглэх “монгол хэл зүйн нэр томъёо” гэсэн ухагдахуунд монгол хэл зүйн бүтээл дэх нэр томъёо, бүр тодруулбал Б.Ринчен Монгол бичгийн хэлний зүй дөрвөн боть бүтээлийн доторх “хэл шинжлэлийн нэр томъёо” гэсэн санааг илтгэж буй юм. Энэхүү судалгаа нь монгол хэл зүйн бүтээлийн хөмрөг байгуулж, түүн доторх нэр томъёог компьютерт автоматаар таниулах судалгааны нэг хэсэг болно.

Тус өгүүлэлд Б.Ринчен Монгол бичгийн хэлний зүй дөрвөн боть бүтээлийн хөмрөгөөс нэр томъёог түүвэрлэн сонгох үндсэн шалгуурыг томъёолж, тухайн шалгуураар түүсэн нэр томъёог зүйлчлэн ангилсан судалгааны үр дүнг танилцуулжээ.

Түлхүүр үг: хэл зүйн бүтээл, нэр томъёо, хэл шинжлэлийн нэр томъёо, монгол бичгийн хэлний зүй, хөмрөг хэл шинжлэл, хэл зүйн бүтээлийн хөмрөг

* © Э.Уранбилэг

✉ *corresponding author Email: uranbilig@gmail.com*

** © Давхарбаяр

Email: dabhvrbayar@163.com

Analysis of Linguistic Terms in Mongolian Grammatical Works

URANBILEG Enkhjargal

School of Mongolian Studies, Inner Mongolia University, Hohhot, China

Davkharbayar

School of Mongolian Studies, Inner Mongolia University, Hohhot, China

Abstract: *With the development of Mongolian linguistic research, a specialized terminology denoting various phenomena in the Mongolian language has emerged. Numerous linguistic works, scientific literature, and textbooks extensively explore diverse aspects of the Mongolian language, employing general linguistic theories and methodologies for analysis.*

A meticulous elucidation of the structure, form, meaning, and usage of terms within these works is paramount for the study, teaching, and furtherance of linguistic research.

Our focus, labeled as “Terms of Mongolian grammar” in this paper, pertains specifically to linguistic terminologies found within the four-volume works known as “Grammar of Mongolian Writing Language” (Mongol biġiin helnii züi) by Academician Byambyn Rinchen. This research endeavor is an integral part of an ongoing research works aimed at constructing a comprehensive corpus of Mongolian linguistic works. Its objective is to facilitate the automatic recognition or identification of linguistic terms from these works by computational or automated means.

In this study, we have formulated foundational criteria for identifying linguistic terms within the aforementioned four-volume works by Byambyn Rinchen. Additionally, we present research outcomes that entail the classification and thematic categorization of selected terms based on the prescribed criteria.

Keywords: *linguistic works, terminology, linguistic terminology, grammar of Mongolian writing language, corpus linguistics, corpus of Mongolian linguistic works*

1. Удиртгал

Монгол хэл шинжлэл бол олон зуун жилийн түүхтэй шинжлэх ухаан болно. Монголчуудын хувьд IX-X зууны үеэс биеэ даасан бичгийн хэлтэй болж, XIII-XIV зууны үеэс эх хэлнийхээ бүтэц, тогтолцоог нарийвчлан судалж, эртний энэтхэг хэл зүйчдийн бүтээлийг орчуулан хэрэглэсээр ирсэн байна. 1243 онд төвөдийн эрдэмтэн Саж бандид Гунгаажалцан *Зүрхний толт* хэмээх монгол хэлний хэл зүй зохиожээ. Түүний дараа 1305 онд уйгур багш Чойжи-Одсэр *Зүрхний толт* хэмээх хэл зүйн бичгийг нэмэн дэлгэрүүлж *Зүрхний толтын тайлбар*-ыг зохиожээ. Ийнхүү монгол хэл шинжлэл үүсэн бүрэлдэж, хэвшин тогтож ирэхдээ хэлнийхээ бүтэц хэлбэрийг заан нэрлэсэн олон нэр томъёог боловсруулан бий болгосон байна.

XVIII-XIX зууны үеэс монгол хэл шинжлэлийн судалгааны цар хүрээ улам бүр өргөжсөний хэрээр нэр томъёо үлэмж баяжиж, урьд урьдаасаа илүү боловсронгуй

болсоор ирсэн нь тухайн үеийн хэл зүйн бүтээлээс тодорхой харагддаг. Тухайлбал, Данзандагвын *Огторгуйн маань* (18-р зууны эхэн үе), Гомбожав, Билгүүндалай нарын *Мэргэд гарахын орон* (1741-1742 он), Галсан *Монгол үгсийн бүгд тайлбар бичиг* (1820 он) зэргийн хэл бичгийн ухааны дурсгалт бичгүүд нь олон улсын монгол судлалын түүхэнд чухал байр суурь эзэлдэг билээ. Энэ үед бурхны шашны сургаал номлол, буддын гүн ухааны сурвалжийг орчуулах, нэр томьёог жигдлэн тогтоох зэрэг бүтээлч үйл ажиллагаа эрчимжиж, бурхан багшийн сургаал номлол болон дорно дахины их таван ухааны олон зохиолыг багтаасан *Ганжуур*, *Данжуур* хэмээх их хөлгөн судрыг орчуулан гаргажээ.

Эдүгээ бидний үед уламжлан үлдсэн Монгол данжуурын доторх дуун ухааны зохиолуудад тохиолдож байгаа хэл шинжлэлийн нэр томьёог жишээ болгон заримыг дурдвал: хэлний авиаг амны хөндийн зайн байдлаар агуу (уужим), цухал (уйтан), эгшиг авианы хэлэгдэх хугацааг охор (богино), урт (урт), маш урт (хэт урт), авианы хэлэгдэх байдлыг хүрэлцэхүй (хамжих), өчүүхэн хүрэлцэхүй (шүргэх), үйлийн цагийг нөгчсөн үйл (өнгөрсөн цаг), эдүгээ болсон үйл (одоо цаг), үүсгэх үйл (ирээдүй цаг) гэх зэргээр нэрлэжээ (Төмөртоого, 2004: 5).

Харин ХХ зууны дунд үеэс энэтхэг – европ хэл шинжлэлийн арга ухаан монгол хэлний судлалд гүнзгий нэвтэрч, хэл шинжлэлийн зохиол бүтээлүүд орос хэлээр дамжин дэлгэрч, их дээд сургуульд үзэх хэл шинжлэлийн ном олноор гарах болсон билээ. Мөн монгол эрдэмтэд монгол хэлнийхээ бүтэц тогтолцоог нарийвчлан судалж орчин цагийн монгол хэлний хэл зүйн бүтээл туурвиж эхэлжээ.

Хэл зүй хэмээх нэр томьёо нь *grammatike techne* буюу *бичиг үгсийн урлаг* гэсэн грек үгнээс гаралтай ажээ. Эрдэмтэн Гончигсүрэн “Үг бүтэх ба хувилгах, үгийг холбож өгүүлбэр бүтээх тухай дүрмийн хураамжийг хэл зүй гэнэ” (1986: 217) хэмээн тодорхойлоод, хэл тус бүр нь өөртөө нарийн баримтлал бүхий тогтсон дүрэм журамтай хэл зүйн байгуулалтай байдаг гэжээ. Мөн Сэцэн нар

Хэл зүй бол хүмүүсийн сэтгэхүйн маш урт удаан хугацааны туршид хийсвэрлэсэн үйл ажиллагааны үр дүн бөгөөд энэхүү хийсвэрлэл нь тодорхой үг өгүүлбэрийн бодит утгыг хамааралгүйгээр зөвхөн үг хувилгах, үгийг холбож өгүүлбэр бүтээх ерөнхий дүрэм зүйг судална. Хэл зүй нь үг бүтээх ба үгсийн хоорондох харьцааг илэрхийлдэг учраас авиа зүй, үгсийн сантай хамсаж хэлний үндсийг бүрдүүлнэ. Авиа зүй, хэл зүй, үгсийн сан гурав бол хэлний шинжлэлийн үндэс бөгөөд тиймээс ч, авианы хэл гэдэг бол энэ гурвын нэгдэл мөн (1991: 391) гэжээ.

Үүнээс үндэслэн хэл зүйн судлах зүйлийг нарийвчлан тогтоохын тулд хэл зүйг үг зүй, өгүүлбэр зүй гэдэг хоёр салбарт хуваадаг байна. Мөн судлах агуулга, зорилго, аргын адилгүйгээс болж хэл зүйг сургуулийн хэл зүй, шинжлэх ухааны хэл зүй, орчин цагийн хэл зүй, эртний хэл зүй, харьцуулсан хэл зүй, тодорхойлсон хэл зүй зэрэгт хуваадаг ажээ.

Ж.Баянсан, Ш.Одонтөр (1995) нар хэл зүй хэмээхийг хоёр зүйл ухагдахуунд холбогдуулан хэрэглэж иржээ. Үүнд: 1. Хэлний байгууламж буюу бүтээвэр зүй, өгүүлбэр зүйн ай, хэлбэр, үг бүтэх аргын тогтолцоо. 2. Хэлний байгууламж түүний ай, тэдгээрийн хоорондын харьцаа хамаарлыг судалдаг хэл шинжлэлийн салбар ухааны нэр юм” гэжээ. Мөн цааш нь дэлгэрүүлж,

Хэл зүй нь хэлний хийсвэрлэл, нэгтгэн дүгнэх үзэгдэлтэй нягт холбоотой юм. Тухайлбал, шинэ үг бүтээж юмыг нэрлэх, тийн ялгалын нөхцөлөөр холбогдсон нийлцээр илрэх янз бүрийн утга, холбоо үг, өгүүлбэрийн утга, хэлбэрийн харьцаа, үйлийн эзэн - үйл байдал, эсвэл, үйл – үйлэнд өртөх юм хоёрын хоорондын харьцаа зэрэг болно. Хэл зүй нь хэл зүйн хийсвэр утга, түүний илрэх хэлбэр хоёрын нэгдэл болох хийсвэр айнуудын тогтолцоо болохынхоо хувьд хэлний амин сүнс юм. Хэл зүйн тодорхой дүрэм журам, байгууламж байхгүйгээр аливаа хэл харилцааны хэрэглүүр болж чадахгүй юм. Хэл зүйн янз бүрийн ай нь өөр хоорондоо харилцан хамааралтай байдаг. Үүгээрээ тогтолцоот шинжтэй юм. Хэл зүйн айг үгд холбогдох, өгүүлбэрт холбогдох гэж өөр хооронд нь эсрэгцүүлэн үзэх нь бий. Гэвч хэл зүй нь авиа зүй, үгийн сантай нөхцөлдсөн холбоо хамааралтай байдаг (1995: 252) гэжээ.

Хэл зүйн ухаан гэж юу болохыг хэл шинжлэлийн тайлбар толь бичигт дараах байдлаар тайлбарлажээ. Үүнд,

Хэлний бүтцийн жам хуулийг судлах шинжлэх ухааныг хэл зүйн ухаан гэнэ. Судлах зорилго ба аргын адил бусаас болж, олон зүйлийн хэл зүй байж болно. Тухайлбал онолын хэл зүй, харьцуулсан хэл зүй, тодорхойлсон хэл зүй, уламжлалт хэл зүй, бүтэц хэл зүй гэх мэт. Үүнд, уламжлалт хэл зүйд үг зүй болон өгүүлбэр зүй багтана. Бүтэц хэл зүйд үгээр бус харин бүтээврээр үндсэн нэгж болгож, үг зүй хийгээд өгүүлбэр зүйн заагийг эвдэн, өгүүлбэр зүйн ухагдахууныг бүхий л хэл зүйн хэвцээнд хүртэл өргөтгөжээ. Орчин цагийн хэл шинжлэлд, хэл зүй нь өгүүлбэрийг ойлгох ба өгүүлбэр үүсгэх дүрмийг системтэйгээр тоочин өгүүлэх хэрэгтэй гэж чухалчилдаг. Монгол хэл зүйн олонх ном зохиолд уламжлалт хэл зүйн ухааныг баримталж, монгол хэлний хэл зүйд үг зүй, өгүүлбэр зүй багтаж буй гэж үзэж байдаг (Yuan Chao, 1992: 57).

Бидний судалгаа нь дээрх олон хэл зүйн ухаан дотроос онолын хэл зүйд хамаарах юм. Онолын хэл зүй гэдэг нь хэлний эрдэмтэд өөрийн хэлний тухай үзэлт болон арга ухаанаараа ямар нэгэн хэлний хэл зүйн системийг тодорхойлохоор зорилго болгосон хэл зүйн ухааныг хэлдэг. Жишээ нь, Ш.Лувсанванданы *Орчин цагийн монгол хэлний бүтэц*, Цэнгэлтэй *Одоо үеийн монгол хэлний зүй*, Б.Ринчен *Монгол бичгийн хэлний зүй* зэрэг бол монгол хэлний онолын хэл зүй болно. Онолын хэл зүйг бас эрдэмтний хэл зүй гэдэг.

Судалгааны зорилго: Энэхүү өгүүлэлд монгол хэлний нэр томъёоны тухай судалгаа, монгол хэл зүйн зарим бүтээл болон хэл шинжлэлийн нэр томъёоны

толь бичгүүдийн агуулга, бүтцийг харьцуулан үзсэний суурин дээр Б.Ринчен *Монгол бичгийн хэлний зүй* дөрвөн боть бүтээл дэх хэл шинжлэлийн нэр томъёоны онцлогийг тодорхойлж, зүйлчлэн ангилахыг зорьсон болно. Өөрөөр хэлбэл тухайн бүтээл доторх ямар үгсийг нэр томъёо гэж үзэх, тэдгээр нэр томъёо нь ямар ангилалд багтаж буйг тоймлон гаргахыг зорьсон болно.

2. Судалгааны арга зүй

Их эрдэмтэн Б.Ринчен (1905-1977) бол алдарт эрдэмтэн зохиолч, гарамгай дуун хөрвүүлэгч, үндэсний монгол хэл шинжлэлийн шинжлэх ухааны ууган доктор (Sc.D), профессор бөгөөд эх орондоо үндэсний монгол судлалыг үүсгэн хөгжүүлж, дэлхий дахинаа монгол өв соёлыг таниулсан бичгийн мэргэдийн нэг билээ. Тэрээр 1956 онд *Монгол бичгийн хэлний зүй* хэмээх ганц сэдэвт зохиол бичиж, Унгар улсад доктор цол хамгаалжээ. Улмаар хэдэн жилийн дараа уг бүтээлээ нэмэн дэлгэрүүлж, *Монгол бичгийн хэлний зүй* тэргүүн дэвтэр *Удиртгал* 1964 онд, дэд дэвтэр *Авиан зүй* 1966 онд, гутгаар дэвтэр *Хэлбэр судлал* 1966 онд, дөтгөөр дэвтэр *Өгүүлбэр зүй* бүтээлээ 1967 онд тус тус хэвлүүлсэн байна. Уг бүтээлийн агуулгыг дөрвөн дэвтэр тус бүрээр нь тоймлон дурдъя.

(1) Тэргүүн дэвтэр *Удиртгал* хэмээх нь *Оршил; Удиртгал; Монгол хэлний шинэтгэлийн үе нээгдсэн нь; Монголын хуучин сургуультаан; Хувьсгалын өмнөх төрийн сургууль; Хувьсгалын өмнөх төрийн сургуулийн сурах бичгийн зүйл; Монгол үсгийн цагаан толгойн зүйл; Монгол үсэгзүйн учир; Монгол хэлний толийн тухай; Монгол үсэг, түүнээс уламжилсан үсгийн зүйлийг латин галигаар тэмдэглэх ёс; Монгол бичгийн хэл; Монгол бичгийн дурсгалын зүйл; Монгол хэл, түүн лүгээ төрөл хэлний зүйл* гэсэн хэсгүүдээс бүрдэнэ. Уг дэвтрийн оршил хэсэгт зохиогч

Монгол бичгийн хэлний энэ ерөнхий удиртгалд авиан зүй, хэлбэр судлал, өгүүлбэр зүйг хэвлэлээс гарахын янар тоймлон мэдэж байвал хэрэгтэй юм сан, монголын судлалд олон улсын эрдэмтний судалсан зүйлийн тойм нь иймэрхүү байгаа, манай хэл бичгийн дурсгалын зүйлээс олж мэдсэн, шинжилсэн зүйл нь иймэрхүү байдаг гэх зэрэг зүйлийг бичиж, монгол хэлээр эдгээрийн тоймыг нь гаргасан зүйл байвал хэрэгтэй юм санж гэж бодсоноо толилууллаа (Ринчен, 2015: 68) хэмээжээ.

(2) Дэд дэвтэр *Авиан зүй* нь *Үсэг зүй; Монгол үсэг; Өгүүлэхүйн эрхтний учир; Эгшиг; Гийгүүлэгч* гэсэн таван бүлгээс бүрдэнэ. *Үсэг зүй, Монгол үсэг* хэмээх эхний хоёр бүлэгт монгол үсгийн зүй, монгол үсгийн учир байдлыг өгүүлсэн боловч “Үсгийг өгүүлэхэд авиан зүйг өгүүлэлгүй байж үл болох учир, үсгийн учрыг өгүүлэнгүүт авиан зүйн байдлыг бас хам өгүүлэлцэн, хойших бөлөгт гарах зүйлтэй түүгээр холболоо” (Ринчен, 2015: 94) гэжээ. Цааших авиан зүйн бүлэгт монгол үсгийн үсэглэвэр эрт цагт ямар дуудлагатай байж, монгол хэлний ямар авиаг тэмдэглэж байсныг латин галигаар тэмдэглэсэнээ тайлбарлан үзүүлж, одоогийн бидний монгол үсгээ дууддаг дуудлага эртний дуудлагаас өөр болох

байдлыг үзүүлж, ямар авиа байснаа одоо манай хэл аялгуунд өнгөрсөн олон зуун жилийн доторх хөгжлийн ёсоор ямар авиа болж ирснийг үзүүлжээ.

(3) Гутгаар дэвтэр *Хэлбэр судлал нь Оршил; Тэргүүн бөлөг: Хэлбэр судлал, Монгол хэлний язгуур үг; Дэд бөлөг: Монгол хэлний үг бүтэхүйн ёс; Гутгаар бөлөг: Нэр үгийн ай, Нэрийтгэл үг, Нэрийтгэл үгийн эм хүйст дагавар, Нэр үгийн тоо* гэсэн хэсгээс бүтнэ. Уг бүтээлийн оршилд зохиогч

Хэл зүйн өрнө зүгийн уламжлал болсон ёсоор авиан зүй, хэлбэр судлал, өгүүлбэр зүй энэ гурван зүйлийг дэс дэсээр нь нэг нэг дэвтэр болгосон үүнд эл гутгаар дэвтэрт монгол үгний үг бүтэх зарчим ёсыг хэлбэр судлал гэж нэрлэв. Энэ хэлбэр судлалын дэвтэр бол, герег-латин хэл зүйн хэмжээ дүрмийн эрхшээлээс ангижирч, монгол хэлний үг зүйг монгол хэлний үг бүтэх өөрийн ёс ухааны нь өөрөөс нь олж гаргах гэж гучин найман жил бодон эрмэлзэж, эргэцэн ажигласны баргийг хэрээрээ эвлүүлсэн зүйл болно (Ринчен, 2015: 12) гэжээ.

(4) Дөтгөөр дэвтэр *Өгүүлбэр зүй* нь *Оршил; Тэргүүн бөлөг: Өгүүлбэр зүй, Үг хорших ёс; Дэд бөлөг: Хориин хүртээх ёс* гэсэн хэсгээс бүрдэнэ. Уг дэвтрийн оршил хэсэгт зохиогч

Монгол хэлний өгүүлбэр зүйн бүх үзэгдлийг нь чанад хязгаарт нь хүртэл судалж бичсэн зүйл гэж үүнийг үзэж болохгүй, доторх сэдэв зүйлийг нь нэг нэгээр нь дэлгэрүүлбэл, нэг зүйл нь нэг ном болох их юм байгаа тул, энэ бол, даруй нэг тойм танилцуулгын төдий бөгөөд, цаашид задруулан бичих юм тун их бийг бас энд дурдах нь миний үүргээ даруй мөн ... хэмээгээд монгол хэлзүй маань ийм учир зүй, тийм зүй тогтоол байдаг юм байна гэж ажин бодоход нь энэ өгүүлбэр зүй тус болох болоосой. Манай эх хэл маань, авиа зүйн үүднээс үзвэл ийм юм байдаг юм байна л; үг бүтэх учир зүй нь хэлбэр судлалын үүднээс ийм ухаантай юм байна л; үг нь нийлж өгүүлбэр болохдоо ийм зүй тогтоолтой байдаг юм байна л гэж мэдэн таньж авахад нь тус болоосой гэж бичсэн болно (Ринчен, 2015: 9) хэмээжээ.

Энэхүү судалгаа нь монгол хэл зүйн бүтээлийн хөмрөг буюу корпус байгуулж, түүн доторх нэр томъёог компьютерт автоматаар таниулах судалгааны нэг хэсэг болно. Уг ерөнхий судалгаанд хэрэглэж буй гол арга бол *хэлний материалын хөмрөгийн хэл шинжлэлийн арга*¹ буюу *корпус хэл шинжлэлийн арга* бөгөөд Б.Ринчен *Монгол бичгийн хэлний зүй* дөрвөн боть бүтээл тус бүрийг латин галигт буулган хөмрөг үүсгэсэн болно. Тус хөмрөгөөс хэл шинжлэлийн нэр томъёог түүвэрлэн сонгохын тулд тодорхой шалгуур тогтоох шаардлагатай юм. Иймээс уг шалгуурыг тогтоох үүднээс монгол хэлний нэр томъёоны судалгаа, түүн дотор хэл шинжлэлийн нэр томъёоны судалгааг нарийвчлан үзэж, тэдгээрийг харьцуулж, анализ хийн нэгтгэн дүгнэх зэрэг аргыг ашиглав.

¹ Англи хэлээр *Corpus linguistics method* хэмээхийг БНХАУ, ӨМӨЗО-ны ном бүтээлд ингэж оноожээ.

3. Монгол хэл зүйн бүтээл дэх хэл шинжлэлийн нэр томьёоны онцлог

Б.Ринчен *Монгол бичгийн хэлний зүй* дөрвөн боть бүтээл нь агуулгын хувьд *авиа зүй, үсэг зүй, үг зүй, өгүүлбэр зүй* зэрэг монгол хэл шинжлэлийн үндсэн ойлголтыг хамруулсан хэл зүйн бүтээл учир хэл шинжлэлийн нэр томьёо тус бүтээлд цөөнгүй байна. Тэдгээр нэр томьёог уг бүтээлийн хөмрөгөөс ялган түүвэрлэх болон зүйлчлэн ангилахын тулд дараах шалгуурыг баримтлан үзлээ.

3.1. Нэр томьёоны онцлог шинжийг харгалзан үзэх нь

Нэр томьёо нь тухайн хэлний үгийн сангийн нэг бүрэлдэхүүн бөгөөд түүний ерөнхий тогтолцоонд захирагдсан байдаг. Нэр томьёо хэмээх ухагдахууныг хэл шинжлэлийн ном бүтээл, стандарт, толь бичиг зэрэгт гадаад, дотоодын олон эрдэмтэд янз бүрээр тодорхойлон томьёолсон байдаг. Тэдгээрээс цөөн хэдийг жишээ болгон дурдъя.

Монгол хэлний их тайлбар толь-д “Мэргэжлийн ухагдахууныг бүрэн дүүрэн илэрхийлэх дан үг болон нийлмэл үг”² гэжээ.

Нэр томьёо судлаач Догсүрэн (1988) “Нэр томьёо бол тусгай үг биш, харин тусгай үүрэгтэй үг, шинжлэх ухаан, техникийн олон салбар тус бүрийн хүрээнд багтдаг юм үзэгдэл, тэдгээрийн тухай ойлголтыг тэмдэглэсэн үгсийг нэр томьёо гэж нэрлэж байгаа юм” хэмээжээ.

Монгол хэл судлал хамтын бүтээлд

Аливаа хэлний үгийн сангийн бүрэлдэхүүнд багтах соёл урлаг, шинжлэх ухаан, техник, эдийн засгийн зэрэг тодорхой салбарт тогтмол хэрэглэгдэх, оновчтой ухагдахуун илтгэсэн, ганц утгатай, зориуд зохион боловсруулсан дан болон нийлэмж үгийг нэр томьёо (term) гэх бөгөөд түүнийг судалдаг ухааныг нэр томьёо судлал (terminology) хэмээн нэрлэдэг (Шагдарсүрэн ба бус, 2022: 92).

Судлаач Н.Мөнхцэцэг “Нэр томьёо гэдэг нь тодорхой нэг шинжлэх ухааны салбарт юм, үзэгдлийн тухай мэдлэгийн нэгж ухагдахууныг тэмдэглэсэн, тусгай үүрэгтэй үг” хэмээн тодорхойлоод

Нэр томьёо нь хэл ба танин мэдэхүйн үйл ажиллагааны үр дүн бөгөөд тусгай мэдлэгийн хүрээнд ухагдахууныг илэрхийлсэн хэлний нэгж юм. Аливаа шинжлэх ухааны нэр томьёо нь 1. Тусагдахуун буюу биет ба биет бус зүйл, 2. Ухагдахуун (concept) буюу хүний оюун санаан дахь хийсвэр дүр зураг, 3. Тодорхойлолт буюу тухайн ухагдахууны шинж чанарыг тодорхойлон бичсэн өгүүлбэр, 4. Нэр томьёо буюу ухагдахууныг нэрлэсэн үг гэсэн дөрвөн бүрдэл хэсэгтэй (2020: 17) гэжээ.

Мөн нэр томьёоны онцлог шинжийг судлаачид янз бүрээр томьёолсон байдаг. Тухайлбал, судлаач Э.Пүрэвжав (2020) “Үг хэрэглээний хэм хэмжээний үндсэн шаардлага бол үгийн сангийн үндсэн утгаар нь үг хэллэгийг зүй зохистой хэрэглэх явдал юм. Энэ шаардлагыг хамгийн тодорхой бөгөөд бодитоор

² <https://mongoltoli.mn/dictionary/detail/65462>

илэрхийлэгч гол нэгж бол нэр томъёо тул дараах зарчмыг баримтална” гээд нэр томъёоны онцлогийг дараах байдлаар томъёолжээ.

Нэр томъёо товч байх. Нэр томъёонд аль болох товч байх шаардлагыг тавьдаг бөгөөд нэг болон хоёр үг, гурван үгээс хэтрүүлэхгүйгээр нэг ухагдахуун илтгэсэн нэр томъёо зохиохыг чухалчилдаг. Энэ нь хэл шинжлэлийн үндэстэй бөгөөд олон үгтэй нэр томъёо дундын нэг утга илтгэх чанараа алддагтай холбоотой.

Ганц утгатай байх. Үгийн сангийн үг ойролцоо, салаа утгатай байж болох боловч нэр томъёоны үүргээр хэрэглэгдэж буй үг зөвхөн ганц утгатай байх бөгөөд тухайн салбартаа нэгж ухагдахуун илтгэнэ.

Сэтгэл хөдлөлийн өнгө аясгүй байх. Нэр томъёог дундаж найруулгаар бичгийн хэлний хэм хэмжээнд нийцүүлэн хэн бүхэнд ойлгомжтой байхаар зохиох ёстой. Иймээс сэтгэл хөдлөлийн өнгө аяс илтгэх баярлаж бахадсан, уурлаж бухимдсан, өхөөрдсөн, зэмлэсэн зэрэг болон уран яруу хэллэг хэрэглэх нь тохиромжгүй юм.

Оновчтой байх. Нэр томъёо нь тухайн ухагдахуунаа яв цав, бүрэн дүүрэн илэрхийлэх нь чухал байдаг тул цаад зүйлийнхээ шинж чанарыг нарийн ажиглаж нэр томъёо тогтоох нь чухал юм. Оновчгүй нэрлэлт хүний сэтгэхүүд хадгалагдан үлддэггүй тул солигдох мартагдах, гадаад үгээр нь хэрэглэх зэрэг сөрөг талтай.

Тогтолцоотой байх. Нэр томъёо нь салангид үгсийн бөөгнөрөл биш бөгөөд тухайн шинжлэх ухааныхаа тогтолцоонд суурилсан шинжтэй байдаг. Нэр томъёо тогтоохдоо энэхүү тогтолцоот шинжийг алдагдуулахгүйгээр хэл зүйн ижил хэлбэр, үгийн сангийн ойролцоо үг зэргийг ашигладаг байна (Пүрэвжав, 2020: 122)

Монгол хэлний зүйн бүтээл дэх нэр томъёог дээрх онцлогийн дагуу түүвэрлэн үзэх нь хамгийн ерөнхий бөгөөд эхний чухал шалгуур болох юм.

3.2. Хэл шинжлэлийн нэр томъёоны онцлогийг харгалзан үзэх нь

Монгол хэл шинжлэлийн нэр томъёоны тухайд тусгай судалгааны бүтээл туурвил гэвэл судлаачдын бичсэн эрдэм шинжилгээний өгүүллээс гадна монгол улсад болон БНХАУ-ын ӨМӨЗО-д монгол бичгээр хэвлэгдсэн хэл шинжлэлийн нэр томъёоны толь бичгүүд цөөнгүй байна.

Хэл шинжлэлийн нэр томъёоны гарал, оноон тогтоох, жигдлэх тухайд Г.Гантогтох “Монгол хэл зүйн зарим уламжлалт нэр томъёоноос” (1989), Чулуун “Монгол хэлний шинжлэлийн зарим нэр томъёоны түүхэн хувирлыг шинжих нь” (1996), Ц.Шагдарсүрэн “Монгол хэлний тийн ялгалын нэр томъёо, түүний гарлын асуудалд” (1998), Түмэнжаргал “Монгол хэл шинжлэлтэй холбогдох зарим нэр томъёог нарийвчлан шинжих нь” (1998), Д.Бадамдорж, “Монгол хэл шинжлэлийн зарим нэр томъёог жигдлэх нь” (2008), Н.Мөнхцэцэг “Орчин үеийн

хэл шинжлэлийн зарим нэр томъёог оноох тухайд” (2013), Дэлгэрмаа “Монгол хэл шинжлэлийн нэр томъёо дахь хятад хэлний нөлөөллийн тухай” (2013) зэрэг эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлэгдсэн байна.

Монгол хэл шинжлэлийн нэр томъёоны тусгай толь бичгүүд ХХ зууны дунд үеэс гарч эхэлжээ. Бүрэн бус бүртгэлээр 1956 оноос 2016 оны хооронд хэвлэгдсэн 17 толь бичиг буйгаас энд төлөөлөгч чанартай 10 толь бичгийг тоймлон авч үзье. Ингэхдээ тухайн бүтээл хэвлэгдсэн он цаг, толь бичгийг зохиосон голлох арга зүй, толгой үгийн тоо, зүйлчилсэн ангилал зэргийг харгалзан үзэв.

(1) Лувсандэндэв А. (1956). Хэлний шинжлэлийн нэр томъёоны монгол орос, орос монгол толь. *Улсын нэр томъёоны комиссын мэдээ №30-31, он.*

Энэхүү толийг зохиогч, эрдэмтэн А.Лувсандэндэв Монгол Улсын их сургуульд хэлний шинжлэл заахдаа эн түрүүн хэрэг болсон нэр томъёонуудыг нэгтгэж толь болгон гаргажээ. Толийн монгол нэр томъёоны заримыг Б.Ринчен *Монгол хэлний зүй* гэх хоёр боть гар бичмэлээс, заримыг Ш.Лувсанвандан *Монгол хэлний зүй* бүтээлээс авчээ. Үлдсэн хэсгийн заримыг орос ба бусад европ хэлнээс орчуулж, заримыг нь монгол хэлний үг бүтэх ёсны дагуу зохиосон байна. Уг бүтээлд 900 орчим хэлний шинжлэлийн нэр томъёог багтаасан бөгөөд *1.Хэл, түүний нийгэмлэгийн мөн чанар ба үүсэн хөгжсөн нь, 2.Авиан зүй, 3.Хэл зүй, 4.Цэг цэглэл, 5.Үгсийн сангийн зүй, 6.Утга зүй, 7.Толь зохиох, 8.Олон хэлийг ангилах нь* гэсэн найман зүйлээр хувааж зүйл тус бүрийг А-Я үсгийн дарааллаар байрлуулжээ. Жишээ нь: *нэр томъёо - термин.*

(2) Лувсанжав Чой. (1964). Хэлний шинжлэл (орос-монгол, монгол-орос хэлээр). *Нэр томъёоны цуврал бичиг II боть.*

Уг толь бичигт хэл зүйн холбогдолтой нэр томъёог голдуу багтааснаас гадна, ерөнхий хэл шинжлэлийн холбогдолтой нэр томъёо хэдэн зуугаадыг, найруулга зүйн холбогдолтой нэр томъёо хэдэн арваадыг, мөн хэл шинжлэлтэй холбоо бүхий утга зохиол, улс төрийн цөөн нэр томъёог тус тус багтаажээ. Мөн хэл бичгийн эрдэмтдийн ном зохиолдоо хэрэглэж олны хүртээл болгосон нэр томъёог хөндөлгүй тэр хэвээр нь авсан боловч зарим оновчгүйг залруулж оруулснаа жишээгээр тайлбарлажээ. Жишээ нь: орос хэлний *ослобление* гэх үгийг *балархай* гэсэн нь үнэхээр ташаа болсныг залруулж *сулрах, сулруулах* гэж монголчилбол оновчтойг дэлгэрэнгүй тайлбарласан байна. Орос монгол, монгол орос нэр томъёог цагаан толгойн дарааллаар байршуулсан 5000 гаруй толгой үгтэй толь юм. Жишээ нь: *зөв бичих зүй - орфография.*

(3) Гончигсүрэн (1986). *Хэлний шинжлэлийн нэр томъёоны тайлбар.* Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.

Зохиогч Гончигсүрэн Өвөр монголын багшийн их сургуульд монгол хэл, утга зохиолын салбарын оюутнуудад хэл шинжлэлийн үндсэн хичээл, тусгай хичээлүүд заах хугацаандаа бага сага хуримтлуулан эмхэтгэж боловсруулан найруулсан хэлний шинжлэлийн үндсэн мэдэц, ухагдахуунуудын тухай

эмхэтгэн гаргажээ. Тус толь бичигт голдуу ерөнхий хэл шинжлэл ба монгол хэл шинжлэлийн 400 шахам нэр томъёо, ухагдахуун тэргүүтнийг хэлний онол ба үйлдлэгийн үүднээс тайлбарласан байна. Жич номын ард орос, хятад, монгол харьцуулсан хэл шинжлэлийн нэр томъёо 1500 гаруй, дэлхийн хэлнүүдийн язгуур төрлийн ангилал, алтай язгуур хэлний тойм байдал, монгол үсгийн хөгжил улирлын хүснэгт, олон улсын галигийн тухай тайлбар, дэлхийн хэлнүүдийн зураг зэргийг дагалдуулжээ. Тус бүтээл нь ерөнхий хэл шинжлэл ба монгол хэл шинжлэлийн нэр томъёог үндсэн ухагдахууных нь хувьд орчин цагийн хэл шинжлэлийн арга зарчмаар боловсруулан тайлбарласан бүтээл юм.

(4) Эрхэлсэн найруулагч Сундуй, Рашдонров, Содбилиг (1987). Хэлний шинжлэлийн нэр томъёо. *Хятад Монгол харьцуулсан нэр томъёоны цуврал бичиг*. Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.

Уг бүтээлийн эх нооргийг Гончигсүрэн, Наранбат хамтаар эмхлэн найруулсан бөгөөд хянан тогтоох хуралд хэл бичгийн эрдэмтэд оролцжээ. Тус толь нь “Хятад монгол харьцуулсан нэр томъёо” хэмээх цувралын нэг бөгөөд хэлний шинжлэлийн үндсэн онол, орчин цагийн монгол хэл хийгээд гадаад хэлний заан сургалт ба судалгааны дунд олон хэрэглэгдэх энгийн нэр томъёог 4000 гаруй зурвас сонгосон байна. Нэр томъёо нь үндсэндээ хэлний шинжлэл, авиа зүй, үгсийн сан, хэл зүй, үсэг бичгийн ухаан, найруулга зүй, логик, толь бичгийн ухаан зэрэг хэсгүүдээр бүрэлдсэн байна.

(5) Yuan Chao, Unench, Galsan, Hairhan. (1992). *Монгол хэл шинжлэлийн толь*. Ляонинг үндэстний хэвлэлийн хороо.

Энэхүү тольд уламжлалт хэл шинжлэлийн нэр томъёоноос гадна бүтэц үзлийн хэл шинжлэлийн аргаар монгол хэлийг судалж байгаа зарим нэр томъёог хамран оруулжээ. Монгол бичгээр хэвлэгдсэн бөгөөд нийт 1300 гаруй толгой үгтэй. Үүнд, монгол хэлний авиа зүй, үсэг бичгийн ухаан, үг зүй, өгүүлбэр зүй, үгсийн сангийн зүй, утга зүй, монгол төрөл хэл ба нутгийн аялгууг багтааснаас гадна бас монгол хэл шинжлэлийн 90 гаруй эрдэмтэн болон 130 номыг танилцуулжээ. Уг толийг 2012 онд “Монгол хэл шинжлэлийн их толь” нэртэйгээр дахин хэвлэсэн байна.

(6) Баянсан, Ж., Одонтөр, Ш. (1995). *Хэлшинжлэлийн нэр томъёоны зүйлчилсэн тайлбар толь*. Улаанбаатар.

Зохиогчид уг бүтээлийг зүйл хуваасан тайлбар толийн жишгээр хийсэн бөгөөд бага гарын нэвтэрхий толийн шинжтэй толь юм. Нэр томъёог монгол хэлээр кирилл үсгээр эх болгон толгойлж латин гарал, франц, англи, орос хэлээрх орчуулгыг дүйлгэн хавсаргасан байна. Уг бүтээлд хэл шинжлэлийн нэр томъёог зүйлчлэхдээ 1. Авиа зүйн нэр томъёо, 2. Үсэг зүйн нэр томъёо, 3. Үгийн сан судлалын нэр томъёо, 4. Хэл шинжлэлийн ерөнхий онолын нэр томъёо, 5. Хэл зүйн нэр томъёо, 6. Найруулга зүйн нэр томъёо гэж зүйлчлэн ерөнхий хэл шинжлэлийн онолын үндсэн асуудлууд хийгээд монгол хэлний

өвөрмөц үзэгдлүүдийг хамарсан 200 орчим нэр томъёог дэлгэрэнгүй тайлбарлажээ.

(7) Сэцэн, Бол. (1996). *Хэлний шинжлэлийн нэр томъёоны тайлбар толь*. БНХАУ. Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.

Энэхүү тольд хэлний шинжлэлийн эл салбар шинжилгээний дотор хэрэглэгдэж байгаа төлөөлөх чанартай, өргөн хэрэгцээт уламжлалт нэр томъёо ба орчин цагийн хэлний шинжлэлийн хөгжлийн явцад шинээр буй болж байгаа нэр томъёонуудаас мянга гаруй толгой үгсийн сонгон оруулжээ. Агуулгын талаар хэлний шинжлэл, хэл аялгуу, авиа зүй, үсэг бичгийн ухаан, хэлний зүй, үгсийн сангийн зүй, утга зүй, найруулга зүй, монгол хэлний тулгар бичиг, улсын дотоод гадаадын зарим алдарт хэл шинжлэлч ба зохиол бүтээлүүдийн нэр томъёог багтаажээ. Монгол бичгээр хэвлэгдсэн бөгөөд толгой үгийг хятад хэлээр дүйлгэн орчуулжээ.

(8) Төмөртогоо Д. (2004). *Хэлшинжилэлийн нэр томъёоны хураангуй толь (монгол-орос-англи)*. Улаанбаатар.

Зохиогч уг тольд хэл шинжлэлийн өмнөх толиудад тогтоосон нэр томъёог хамруулахын зэрэгцээ эрдэмтэн судлаачдын бүтээлүүдэд олонтоо тохиолддог нэр томъёонуудыг багтаажээ. Агуулгын хувьд 1. *Бичиг үсэг, Үсэг зүй, 2. Авиа зүй, 3. Үг зүй, 4. Өгүүлбэр зүй, 5. Үгсийн сан, 6. Найруулга зүй, 7. Хэл шинжлэл, 8. Дэлхийн хэлнүүд, 9. Алтайн хэлнүүд* хэмээн 9 хэсэгт хуваагаад холбогдох нэр томъёог монгол, орос, англи гурван хэлээр цагаан толгойн дарааллаар жагсаажээ. Мөн монгол судлалын нэрт эрдэмтэд болон цуврал сэтгүүл, хэлний ангилал зэргийг багтааж, лавлагааны чухал хэрэглэгдэхүүн болгосон байна. Жишээ нь: *Бичиг үсэг, үсэг зүй хэсэгт барын бичиг - ксилография - xylograph*. Нийт 3000 гаруй толгой үгтэй.

(9) Зээнямбуу, Ч., Базаррагчаа, М. (2014). *Хэлшинжилэлийн нэр томъёоны тайлбар толь*. Улаанбаатар.

Зохиогчид уг толь бичигтээ тогтсон уламжлалт нэр томъёоноос гадна ХХ зууны эцэс ХХI зууны эхэн үеэс хэл шинжлэлд бусад салбар ухааны хөгжил ололт амжилттай уялдан үүссэн шинэ нэр томъёо, ойлголт ухагдахууныг түүвэрлэн авч оруулжээ. Монгол хэлээр эх болгон толгойлж ихэнх нэр томъёоны гарал үүслийг зааж өгсөн байна. Жишээ нь: *бичгийн хэл - literary language - литературный* язык гээд дэлгэрэнгүй тайлбарлажээ. Уг тольд 900 орчим нэр томъёоны тодорхойлолт, агуулгыг монгол хэлээр тайлбарлаж, онолын үндэслэл болон дүгнэлт, тайлбарлаж буй үзэгдлийг ойлгоход нэмэр болохуйц жишээ баримтыг хавсаргажээ. Толийн төгсгөлд нийт толгой үгсийг *Авиа зүй, Үсэг зүй, Бүтээвэр зүй, Үг бүтэх ёс, Үг судлал, Утга судлал, Аялгуу, Оноосон нэр зүй, Толь зүй, Хэл зүй, Бүтээвэр судлал, Холбоо үг, Өгүүлбэр зүй, Цэг цэглэл, Эх, Найруулга зүй, Хэлний ай, Хэлнүүд, Хэл шинжлэлийн салбар ухаан, Хэл шинжлэлийн суурь, хавсарга чиглэлүүд, Үгийн гарал судлал* хэмээн зүйлчлэн ялгасан байна.

(10)Төмөртоогоо, Д., Энхбат, Д., Бат-Ирээдүй Ж. (2016). *Хэл шинжлэлийн монгол-англи толь бичиг*. МУИС Пресс хэвлэлийн газар.

Энэхүү толийн зохиогчид өмнө нь толь бичиг зохиож байсан өөрсдийн туршлагадаа дулдуйдан, мөн монгол хэл шинжлэлээр гарсан сурах бичиг, эрдэм шинжилгээний бүтээл, гарын авлага, толь бичиг тэргүүтнийг шүүрдэн үзээд монгол англи хэлээрх нэр томьёоны толийг бүтээжээ.

Хэл шинжлэлийн нэр томьёоны толь бичгүүдийн зохиосон арга, толгой үгийг сонгосон зарчмыг харьцуулан ажиглахад олонх нь алдарт хэл шинжээчдийн хэл зүйн бүтээл болон түүн доторх олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөж хэвшиж тогтсон нэр томьёог үндсэн нэр томьёо болгон сонгон оруулжээ. Үүнээс гадна эрдэмтдийн үзэл, онол арга өөр байгаагаас хэл шинжлэлийн нэг ойлголтыг өөр өөрөөр нэрлэсэн байдал цөөнгүй байна. Тэдгээрийг зарим толь бичигт аль аль хувилбараар нь хамт оруулж, зарим толь бичигт шинээр оноон нэрлэж эсвэл аль нэгийг нь журамлаж оруулахыг хичээсэн байна.

Монгол хэл шинжлэлийн нэр томьёоны судалгаа болон хэл шинжлэлийн нэр томьёоны толиудын онцлог шинжид тулгуурлан “хэл шинжлэлийн нэр томьёо”-ны онцлогийг дараах байдлаар томьёолж болохоор байна. Үүнд,

1. Хэлийг судалдаг шинжлэх ухааны ойлголт ухагдахууныг илтгэсэн үг хэллэгийг хэл шинжлэлийн нэр томьёо гэнэ. Хэлний шинжлэл бол хийсвэрлэл ихтэй нарийн төвөгтэй ухаан бөгөөд хэлний шинжлэлийн нэр томьёо бол хэлний онолын мэдлэгийг зөв тайлбарлах ба хэлний үйлдлэгийг зөв жолоодох багаж хэрэгсэл юм.
2. Хэл шинжлэлийн нэр томьёог зохиодог, бүтээдэг хүмүүс бол хэл шинжлэлч эрдэмтэд, судлаачид бөгөөд тэдгээрийн бүтээл туурвилд нэр томьёо анх хэрэглэгдэж, аажим аажмаар хэвшин тогтдог. Хэл шинжлэлийн ном бүтээл, ялангуяа хэл зүйн бүтээлүүдээс хэл шинжлэлийн нэр томьёоны толийг бүтээх буюу толгой үгсийг сонгон оруулдаг ажээ.
3. Хэл шинжлэлийн нэр томьёог хэрэглэгч хүмүүс бол энэ чиглэлээр сурч буй оюутан, сурагчид, судалгаа хийж буй эрдэм шинжилгээний ажилтан нар бөгөөд бүр цаашилбал хэлний тухай шинжлэх ухааныг сонирхогч нарын дунд хэрэглэгдэнэ. Иймээс хэрэглээний хувьд тодорхой хязгаартай бөгөөд зөвхөн хэл шинжлэлийн мэргэжлийн хүмүүс эзэмшин хэрэглэнэ.
4. Хэл шинжлэл нь бие даасан шинжлэх ухаан болохын хувьд судлах арга болон судлагдахууны хувьд өөр өөр салбар ухаан болж задарна. Тиймээс хэл шинжлэлийн нэр томьёог дотор нь тэдгээр салбар ухаанаар ангилан зүйлчилж болдог. Жишээ нь үгийн сангийн нэр томьёо, авиа зүйн нэр томьёо, өгүүлбэр зүйн нэр томьёо гэх мэт.
5. Хэл шинжлэл нь уран зохиол, сэтгэл судлал, танин мэдэхүй, гүн ухаан зэрэг бусад шинжлэх ухаантай холбогдох тул тэдгээрийн нэр томьёо хэл шинжлэлийн бүтээлүүдэд түгээмэл хэрэглэгдэж зарим тохиолдолд нэвтэрч орсон байна.

Судлаач Н.Мөнхцэцэг “Хэл шинжлэлийн нэр томьёо гэдэг нь товчхондоо хэлний тухай шинжлэх ухааны ойлголт, ухагдахуунуудыг нэрлэсэн нэр томьёог хэлнэ” (2020: 39) гээд хэл шинжлэлийн нэр томьёоны өвөрмөц онцлогийг дараах байдлаар томьёолсон байдаг. Үүнд,

- Хэл шинжлэлийн нэр томьёо нь бусад нэр томьёоны тогтолцоонд зориулагдсан байдаг;
- Шинжлэх ухаан дундын шинжтэй;
- Ховор давтагдашгүй шинж чанартай; Өөрөөр хэлбэл, тодорхой нэг эрдэмтний хэл шинжлэлийн онолд оруулсан чухал айг нэрлэдэг;
- Хэл шинжлэлийн нэр томьёоны хэрэглээ нь тухайн хэл шинжлэлч, хэл шинжлэлийн ямар дэг сургуулийнх вэ гэдгийг таних нэг шалгуур болдог (2020: 40) хэмээжээ.

3.3. Хэл шинжлэлийн нэр томьёог ангилахад бусад хэл зүйн бүтээлийн бүтэц, агуулгыг харгалзан үзэх нь

Эрдэмтэн Ш.Лувсанвандан хожим олны дунд *Лу багшийн цагаан ном* хэмээн алдаршсан *Монгол хэлний зүй* хэмээх бүтээлээ 1939 онд туурвижээ. Уг бүтээлд “Аливаа нэгэн хэлний хуулийг судлах ухааныг хэлний зүй хэмээмүй. Хэлний зүйг олон улсын үгээр грамматик гэх бөгөөд угтаа грек хэлний үг болой. Хэлний зүй болбоос дотроо фонетик (phonetic) буюу *дууны сургаал*, морфологи (morphology) буюу *үгсийн сургаал*, синтакс (syntax) буюу *өгүүлбэрийн сургаал* хэмээх гурван анги хуваагдмуй” гэжээ. Мөн

Дэлхий дахины эрдэмтэд манай монголын хэл бичгийг судалж эхэлсээр хэдэн он өнгөрч буй, энэ талаар гадаад хэлээр зохиогдсон монгол хэлний зүйг судалсан бичиг зохиол өдий төдий болжээ. Гэвч тэр бүгдийг сурч судлах явдал маш удаан. Монгол хэл дээр хэвлэгдсэн монгол хэлний зүйн бичгүүд болбоос маш товчийн дээр, зарим талаар монгол хэлийг судалсан хамгийн сүүлчийн шинжлэлийг баримталж чадаагүй зүйл бий (1939: 4) хэмээжээ.

Тус бүтээл нь *Удиртгал*, *Дууны сургаал (phonetic)*, *Үгсийн сургаал (morphology)*, *Өгүүлбэрийн сургаал (syntax)*, *Цэг тэмдэг хэрэглэх заавар* гэсэн ерөнхий бүлгүүдийн хүрээнд бичсэн тусгай мэргэжлийн ангид үзэх сурах бичгийн чанартай хэл зүйн бүтээл юм.

Эрдэмтэн Цэнгэлтэй 1970-аад оны үед, монгол хэлний зүйн талаар хийсэн судалгааны суурин дээр *Одоо үеийн монгол хэлний зүй* гэх номыг туурвиж 1979 онд хэвлэжээ. Тэр ном нь 1984 он хүртэл гурвантаа хэвлэгдсэн бөгөөд 1999 онд сайжруулан засан хэвлэсэн байна. Тус нэмэн зассан хэвлэл нь *өмнөх үг, хэлний авиа ба үсэг бичиг, үгийн зүй, өгүүлбэрийн зүй, үг бүтээх ёс* гэх ангиудаар бүрэлдсэн нь уул хэвлэлтэй адил боловч түүний доторх бүлэг хэсгийн хуваарилал, бүлэг хэсгийн доторх агуулга жич зарим дурдалт, томьёолол, үзэлт, жишээ, галиг хүртэл нэлээд засвар орсон байна. Тус ном нь 2018 онд монгол улсад кирилл үсгээр хэвлэгджээ. Уг бүтээлийн ерөнхий агуулга нь *1. Хэлний авиа*

ба үсэг бичиг, 2. Үгийн зүй, 3. Өгүүлбэрийн зүй, 4. Үг бүтэх ёс хэмээх дөрвөн ангид хуваан бичжээ.

Монгол Улсад хэл шинжлэлийн салбараар сургалт, судалгаа эрхэлдэг байгууллагын эрдэмтдийн хамтран бүтээсэн *Монгол хэл судлал* хэмээх 15 боть бүтээл 2022 онд хэвлэгдсэн билээ. Уг бүтээл нь хэл шинжлэлийн нийтлэг онол, орчин үеийн арга зүйн үүднээс эх хэлнийхээ бүтэц, тогтолцоог тодруулан гаргасан бүрэн хэл зүйн бүтээл юм. Уг бүтээлийн IV боть *Монгол хэлний түүх*, V боть *Түүхэн хэл зүй*, VI боть *Нутгийн аялгуу*, VII боть *Үсэг зүй*, VIII боть *Авиа зүй*, IX боть *Үг зүй*, X боть *Үгийн сан, утга зүй*, XI боть *Өгүүлбэр зүй*, XII боть *Эх судлал*, XIII боть *Бичгийн хэл*, XIV боть *Танихуйн хэл шинжлэл, хэлний соёл судлал*, XV боть *Хэрэглээний хэл шинжлэл, хэл боловсруулалт, түгээмэл хэл зүй* хэмээх ботиудад сэдэвт холбогдох нэр томъёог хавсралтаар оруулсан нь орчин үеийн монгол хэл шинжлэлийн нэр томъёоны судалгаанд чухал ач холбогдолтой юм. Тухайлбал, *Үгийн сан, утга зүй* хэмээх X ботийн хавсралт хэсэгт 203 нэр томъёог монгол - орос - англи хэлээр жагсаажээ. Жишээ нь: *эсрэг утгат үг - антонимы - antonyms*. Мөн *Бичгийн хэл* хэмээх XIII ботийн Зөв дуудах зүй хэсэгт *Улаанбаатар аялгуу* гэсэн нэр томъёог шинээр зохион хэрэглэжээ.

Эрдэмтдийн хэл зүйн бүтээлүүдийг ажиглавал номын бүтэц бүлгүүдийн хуваарилалт нь монгол хэлний дотоод мөн чанар, бүтэц зохион байгуулалтыг тусган харуулах бөгөөд орчин цагийн монгол хэлний бүтэц, зохион байгуулалт, хоорондын уялдаа холбоог хувь судлаачийн үзэл онол, аргын үүднээс задлан тайлбарлажээ. Тийм ч учраас нэр томъёоны бичлэгийн хэлбэр, онолт зэрэг нь өөр хоорондоо ялгаатай байдал цөөнгүй тохиолдох ажээ.

4. Судалгааны үр дүн

4.1. Монгол хэл зүйн бүтээлээс хэл шинжлэлийн нэр томъёог сонгон түүвэрлэсэн нь

Б.Ринчен *Монгол бичгийн хэлний зүй* дөрвөн боть бүтээлийн хөмрөгөөс хэл шинжлэлийн нэр томъёог түүвэрлэн үзэхэд давхардаагүй тоогоор 600 гаруй нэр томъёо байна. Нэр томъёог сонгохдоо тухайн үг ерөнхий нэр томъёоны онцлог шинж болон хэл шинжлэлийн нэр томъёоны онцлогийг илэрхийлж буй эсэх, мөн хэл шинжлэлийн нэр томъёоны толь бичигт буй эсэх гэсэн үндсэн шалгуураар шүүн түүвэрлэсэн болно.

Хүснэгт 1. Нэр томьёог түүвэрлэн жагсаасан байдал

| | A | B | C | D | E |
|----|------------------------------|----------|--------------------|---------------------------------|--|
| 1 | Нэр томьёо | Ангилал | Номын бүлэг | Латин галиг | Жишээ өгүүлдэр |
| 2 | өгүүлэхүйн эрхтэн | авиа зүй | 2.3 uguuleh erhten | OGULEHUI-YIN ERHETEN | HUMUN-U UGE HELEHU-DU OROLCAN ABIY A BUTUC |
| 3 | өгүүлэхүйн эрхтний ажиллагаа | авиа зүй | 2.3 uguuleh erhten | OGULEHUI-YIN ERHETEN-U AJLLAG A | ABIYAN JUI-YIN Y060N-DV OGULEHUI-YIN ERHETI |
| 4 | ам | авиа зүй | 2.3 uguuleh erhten | AMA | EGUN-DU HELE-YI AMAN D0TOR A-BAN, HODELUL U |
| 5 | хэл | авиа зүй | 2.3 uguuleh erhten | HELE | HELE GEDEG ERHETEN OGULEHUI-DUR MASI CHVL |
| 6 | хоолой | авиа зүй | 2.3 uguuleh erhten | HOGOLAI | TEGUN-U DOGOGSI-BAN VNIJIGSAN UJUGUR-I HEUHE |
| 7 | мөгөөрсөн хоолой | авиа зүй | 2.3 uguuleh erhten | MOGERSUN HOGOLAI | ABIYAN JUI-DU HUMUN-U UGE BUTUGEGCI ABIY A- |
| 8 | дууны хөвч | авиа зүй | 2.3 uguuleh erhten | DAGVN-V HOBICI | TOBONGHEI-YIN D0TOR A NI DAGVN-V HOBICI GEIJ |
| 9 | дуу авна | авиа зүй | 2.3 uguuleh erhten | DAGV ABIY A | DAGVN-V HOBICI SVNVNAG VYAN HATAN YAGVM . |
| 10 | дууны өтгөн шингэн | авиа зүй | 2.3 uguuleh erhten | DAGVN-V ODHEN SINGGEN | DAGVN-V ODHEN SINGGEN BAYIDAL NI DAGVN-V |
| 11 | хамрын хөндий | авиа зүй | 2.3 uguuleh erhten | HAMAR-VN HONDEI | ABIYAN-V BAYIDAL NI AGVSHI-ACA GARCVC BAYIG |
| 12 | түүш | авиа зүй | 2.3 uguuleh erhten | TUGUSI | TANGNAI NI SIDUN-U JUG YABVGSAGAR, JLAGAR I |
| 13 | тагнай | авиа зүй | 2.3 uguuleh erhten | TANGNAI | NARMAI NI TANGNAI GEDEG-TU TVLVN, TERE TAN |
| 14 | нармай | авиа зүй | 2.3 uguuleh erhten | NARMAI | NARMAI B0I BVLICING-TAI TVLA, TERE BVLICING-VN |
| 15 | хэлний үзүүр | авиа зүй | 2.3 uguuleh erhten | HELEN-U UJUGUR | TERE SAGSIRAHV ABIY A-YI HELEN-U UJUGUR-I TI |
| 16 | хэлний магнай | авиа зүй | 2.3 uguuleh erhten | HELEN-U MANGNAI | TANGNAI-YIN TVSIY A-DVR ONOGDAHV HELEN-U HI |
| 17 | хэлний ар (онги) | авиа зүй | 2.3 uguuleh erhten | HELEN-U ARV | NARMAI-YIN TVS ONOGDAHV HELEN-U HESEG-I HEL |
| 18 | хэлний уг | авиа зүй | 2.3 uguuleh erhten | HELEN-U VG | OGULEHUI-DUR TANGNAI-YIN ARV, NARMAI, HEUHE |
| 19 | багалзуур | авиа зүй | 2.3 uguuleh erhten | BAGALJAGVR | TOBONGHEI BAGALJAGVR-VN HOLBOGDAL EDEGER |
| 20 | төвөн, төвшөг, төвөнхий | авиа зүй | 2.3 uguuleh erhten | TOBONGGI | TOBONG (төвшөг) BVYV TOBONGGI (төвшөг) ,BA |
| 21 | шүд | авиа зүй | 2.3 uguuleh erhten | SIDU | SIDUN-U ABIYAN-V JUIL-DU MONGGOL HELEN-U JARI |
| 22 | үүдэн шүд | авиа зүй | 2.3 uguuleh erhten | EGUDEN SIDU | SIDUN-U ABIYAN-V JUIL-DU MONGGOL HELEN-U JARI |
| 23 | хүүхэн хэл | авиа зүй | 2.3 uguuleh erhten | HEUHEN HELE | EGUN-DU, HEI-YIN TOBONGHEI-ECE GARHV JAM GV. |
| 24 | тагнайн ар | авиа зүй | 2.3 uguuleh erhten | TANGNAI-YIN ARV | NARMAI-YIN TVS ONOGDAHV HELEN-U HESEG-I HELI |
| 25 | уруул | авиа зүй | 2.3 uguuleh erhten | VRVGVL | YAGVM A HELEHU-DU VRVGVL BASA ULEMJINEN E |
| 26 | дэд уруул | авиа зүй | 2.3 uguuleh erhten | DEGEDU VRVGVL | VRVGVL-VN TVHAI OGULEHU-DU, DEGEDU DOORAD |
| 27 | доод уруул | авиа зүй | 2.3 uguuleh erhten | DOORADV VRVGVL | VRVGVL-VN TVHAI OGULEHU-DU, DEGEDU DOORAD |

4.2. Хэл зүйн бүтээл дэх хэл шинжлэлийн нэр томьёог зүйлчлэн ангилсан нь

Хэл зүйн бүтээлийн хөмрөгөөс түүвэрлэсэн хэл шинжлэлийн нэр томьёог зүйлчлэн ангилахын тулд хэл шинжлэлийн зүйлчилсэн толь бичгүүдийн ангилал болон хэл зүйн бүтээлийн агуулга, бүтцийг харгалзан үзэв.

Б.Ринчен Монгол бичгийн хэлний зүй бүтээл дэх нэр томьёог агуулгын хувьд *Үсэг зүй, Авиа зүй, Үг зүй, Өгүүлбэр зүй, Үгийн сан, Ерөнхий* гэсэн зургаан хэсэгт хуваан үзэж болохоор байна. Эдгээр нь тус бүтээлийн аль хэсэгт агуулагдаж буйг тоймлон дурдвал дараах байдалтай байна.

- 1. Үсэг зүйн нэр томьёо:** *Удиртгал* хэмээх нэгдүгээр ботийн Монгол үсгийн цагаан толгойн зүйл, Монгол үсэг зүйн учир хэсэг, *Авиан зүй* хэмээх хоёрдугаар ботийн тэргүүн бүлэг *Үсэг зүй*, дэд бүлэг *Монгол үсэг* хэмээх хэсгүүдэд багтаж буй үндсэн нэр томьёог энэ ангилалд хамааруулж үзэв. Жишээ нь: *цагаан толгой, үсгийн зурлага, титим, шүд, их үсэг, бага үсэг, асуух тэмтэг, тод үсэг, вагиндра үсэг.*
- 2. Авиа зүйн нэр томьёо:** Нэгдүгээр боть *Удиртгал* хэсгийн уг ангилалд холбогдох нэр томьёо, *Авиан зүй* хэмээх хоёрдугаар ботийн *Өгүүлэхийн эрхтний учир, Эгишг, Гийгүүлэгч* хэмээх бүлэгт багтаж буй үндсэн нэр томьёог энд хамааруулж үзэв. Жишээ нь: *авиалбар, эгишг, гийгүүлэгч, шүргэх авиа, хамжих авиа, өгүүлэхүйн эрхтэн, уруул, түүш.*
- 3. Үг зүйн нэр томьёо:** Нэгдүгээр боть *Удиртгал* хэсгийн зарим холбогдох нэр томьёо, *Хэлбэр судлал* хэмээх гуравдугаар ботийн Монгол хэлний үг бүтэхүйн *ёс нь, Нэр үгийн ай, нэрийтгэл үг, Нэрийтгэл үгийн эм хүйст дагавар, Нэр үгийн тоо* гэсэн хэсгүүдэд багтаж буй үндсэн нэр томьёог энд хамааруулж үзэв. Жишээ нь: *үндэс, язгуур, дагавар, амид язгуур, сөнөсөн*

язгуур, нэр үг, тийн ялгал, үйл үг, заасан үг.

4. **Өгүүлбэр зүйн нэр томъёо:** Нэгдүгээр боть *Удиртгал* хэсгийн зарим холбогдох нэр томъёо, *Өгүүлбэр зүй* хэмээх дөрөвдүгээр ботийн *Үг хорших ёс, Хоришин хүртээх ёс* гэсэн агуулгад багтах нэр томъёог энд хамааруулж үзэв. Жишээ нь: *хоршоо үг, дуурайн хоршоо үг, аялга хоршоо үг, давтац үг, нөхцөл үг, цагт нэр, урьдчилах нөхцөл үг, үргэлжлэх нөхцөл үг, одоо үргэлжилсэн цаг, ирээдүйд үргэлжилсэн цаг.*
5. **Үгийн сангийн нэр томъёо:** Нэгдүгээр боть *Удиртгал* хэсгийн *Монгол хэлний толийн тухай*, бусад ботийн холбогдох нэр томъёог энд хамруулан үзэв. Жишээ нь: *монгол үг, гадаад үг, нутгийн хар үг, журамласан үг, толь бичиг, тайлбар толь, газар усны нэр, хэвшмэл хэллэг.*
6. **Ерөнхий нэр томъёо:** Үүнд, Нэгдүгээр боть *Удиртгал* хэсгийн *Монгол бичгийн хэл, Монгол бичгийн дурсгалын зүйл, Монгол хэл, түүн лүгээ төрөл хэлний зүйл* хэмээх хэсэгт агуулагдах үндсэн нэр томъёо, бусад ботийн холбогдох нэр томъёог энд хамруулан үзэв. Жишээ нь: *бичгийн хэл, зөв бичих зүй, аман аялгуу, хэлний сэтгэхүй, ярианы хэл* гэх мэт.

5. Дүгнэлт

Их эрдэмтэн Б.Ринчен *Монгол бичгийн хэлний зүй* хэмээх бүтээлээ өөрийн мэдэж туулсан туршлага, цуглуулсан арвин хэрэглэгдэхүүн, гадаад дотоодын эрдэмтдийн санал бодол, мэргэжлийн ангийн оюутнуудад уншсан хэл шинжлэлийн лекц зэрэгтээ тулгуурлан туурвисан бөгөөд өөрийнх нь тэмдэглэсэн ёсоор нийгмийн захиалгын шинжтэй байжээ. Академич Л.Болд энэхүү бүтээлийн талаар “Монголчууд бичгийн хэлний арвин их өв сантай боловч тухайн үед түүнийг нь хэл шинжлэлийн ухааны үүднээс судалсан судалгаа зөвхөн гадаадад хийгддэг асан ба өөрийн оронд судалгаа бараг үгүй, манай улсад хэл бичгийн мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн гарааны үе, нөгөө талаас үзвэл монгол хэлний судлал Европ дахинд үүсэж хөгжөөд багагүй хугацаа өнгөрсөн авч орчин цагийн хэл шинжлэлийн арга төдий л дэлгэрч амжаагүй, тэр бүү хэл нэр томъёо нь ч бүрэн цэгцэрч чадаагүй байхад энэхүү зохиолоо туурвисан байдаг” (Ринчен, 2015: 4) хэмээн дүгнэжээ. Тийм ч учраас энэхүү бүтээл дэх нэр томъёоны зарим нь одоогийн тогтсон томъёоллоос нэлээд өөр нэршилтэй болсон мөн нэг ухагдахууныг хэд хэдэн хувилбараар нэрлэсэн зүйл ч ажиглагдаж байна.


Онолын хэл зүйн бүтээл буюу нэг эрдэмтний туурвисан бүтээл дэх нэр томъёоны судалгаа хийх нь уг бүтээлийн агуулга, санааг бүрэн гүйцэт ойлгож ухаарахад чухал ач холбогдолтой бөгөөд тухайн салбар ухааны хөгжилтийн явц, түүхэн байдлыг бүтээл хэвлэгдсэн он цагтай нь харьцуулан ажиглахад сонирхолтой дүгнэлтүүдийг хийж болохоор байна. Мөн бусад эрдэмтний хэл зүйн бүтээлийн нэр томъёог нарийвчлан судалж өөр хооронд нь харьцуулан үзсэнээр хэвшин тогтоогүй нэр томъёог аль оновчтойгоор нь журамлах зэрэг нэр томъёоны ажилд дэмжлэг үзүүлэх боломжтой байна.

Б.Ринчен *Монгол бичгийн хэлний зүй* хэмээх дөрвөн боть бүтээл нь агуулгын хувьд авиа зүй, үсэг зүй, үг зүй, өгүүлбэр зүй зэрэг монгол хэл шинжлэлийн үндсэн ойлголтыг хамруулсан хэл зүйн бүтээл учир хэл шинжлэлийн нэр томьёо тус бүтээлд цөөнгүй байна. Уг бүтээл дэх нэр томьёог сонгон түүвэрлэх ерөнхий шаардлага нь нэр томьёо гэж юу болох томьёолол, хэл шинжлэлийн нэр томьёоны өвөрмөц онцлог зэргийг харгалзан үзэх нь голлох шалгуур болохын сацуу хэл шинжлэлийн нэр томьёоны толь бичгүүдийн толгой үгийг харгалзан үзэх нь бас нэгэн чухал шалгуур болж байна. Уг бүтээл нь монгол хэлийг монгол хэлнийх нь онцлогт тулгуурлаж бичсэн, монгол хэлний судлалын шинэ үеийг нээсэн анхны бүтээл бөгөөд орчин цагийн монгол хэл шинжлэлийн нэр томьёо жигдэрч цэгцрэх, хэл шинжлэлийн нэр томьёоны анхны толь бичгүүд гарахад чухал нөлөө үзүүлсэн суурь бүтээл юм.

Ном зүй

- Баянсан, Ж., Заяабаатар, Д.** (2010). *Шадавын Лувсанвандан бүтээлийн чуулган. I боть. Монгол хэлний зүй*. Улаанбаатар: Соёмбо. [Bayansan, J., Zayabaatar, D. *Shadaviin Luvsanvandan бүтээлийн чуулган. I boti. Mongol helnii züi*. [Mongolian Grammar]. Ulaanbaatar: Soyombo printing, 2010.]
- Баянсан, Ж., Одонтөр, Ш.** (1995). *Хэл шинжлэлийн нэр томьёоны зүйлчилсэн тайлбар толь*. Улаанбаатар. [Bayansan, J., Odontür, Sh. *Hel шинжлэлийн нэр томьёоны зүйлчилсэн тайлбар толи*. [Thematic dictionary of Linguistic term]. Ulaanbaatar. 1995.]
- Гончигсүрэн.** (1986). *Хэлний шинжлэлийн нэр томьёоны тайлбар*. Хөх хот: Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. [Gonchigsüren. *Hel шинжлэлийн нэр томьёоны тайлбар*. [Definition of Linguistic Term]. Hoh hot: Inner Mongolia Educational Publishing. 1986.]
- Догсүрэн, Ч.** (1988). *Монгол нэр томьёо оноох, толилох, жигдлэх асуудал*. Улаанбаатар: ШУАХ. [Dogsüren, Ch. *Mongol ner tomio onooh, toliloh, jigdleh asuudald*. Ulaanbaatar. 1988.]
- Мөнхцэцэг, Н.** (2020). *Нэр томьёоны орчуулга судлал*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК. [Münkhtsetseg, N. *Ner tomionii orchuulga sudlal* [Translation-Oriented Terminology Studies]. Ulaanbaatar: Soyombo printing LLC. 2020.]
- Пүрэвжав, Э.** (2020). *Монгол хэлний хэм хэмжээ судлал*. Улаанбаатар: Соёмбо. [Purevjav, E. *Mongol helnii hem hemjee sudlal* [Studies on Linguistic norms of Mongolian language]. Ulaanbaatar: Soyombo printing. 2020.]
- Ринчен, Б.** (2015), *Монгол хэлний зүйн бичиг. Удиртгал, Авиа, Үг, Өгүүлбэрийн зүй*. Улаанбаатар: Соёмбо. [Rinchen, B. *Mongol helnii züin bichig* [Writing of Mongolian Grammar]. Ulaanbaatar: Soyombo printing. 2015.]
- Ринчен, Б.** (2015). *Монгол бичгийн хэлний зүй. Авианзүй*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Rinchen, B. *Mongol biçgiin helnii züi* [Grammar of Mongolian Writing Language]. Ulaanbaatar: Soyombo printing. 2015.]
- Ринчен, Б.** (2015). *Монгол бичгийн хэлний зүй. Өгүүлбэрзүй*. Улаанбаатар: Соёмбо

- принтинг. [Rinchen, B. *Mongol bičgiin helnii züi* [Grammar of Mongolian Writing Language]. Ulaanbaatar: Soyombo printing. 2015.]
- Ринчен, Б.** (2015). *Монгол бичгийн хэлний зүй. Удиртгал*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Rinchen, B. *Mongol bičgiin helnii züi* [Grammar of Mongolian Writing Language]. Ulaanbaatar: Soyombo printing. 2015.]
- Ринчен, Б.** (2015). *Монгол бичгийн хэлний зүй. Хэлбэрсудлал*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Rinchen, B. *Mongol bičgiin helnii züi* [Grammar of Mongolian Writing Language]. Ulaanbaatar: Soyombo printing. 2015.]
- Төмөртоого, Д.** (2004). *Хэлшинжлэлийн нэр томъёоны хураангуй толь*. Улаанбаатар: Адмон ХХК. [Tumurtogoo, D. *Hel шинjleliin ner томьони хураангуй толи* [A Concise dictionary of Linguistics]. Ulaanbaatar: Admon LLC. 2004.]
- Шагдарсүрэн, Ц., Бадамдорж, Д., Самбуудорж, О., Пүрэвжав, Э., Баттөгс, Ш., Гэрэлмаа, Г.** (2022). *Монгол хэл судлал. X боть. Үгийн сан, утга зүй*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Shagdarsuren, Ts., Badamdorj, D., Sambuudorj, O., Purevjav, E., Battugs, Sh., Gerelmaa, G. *Mongol hel sudlal. X boti. Ugiin san, utga zui* [Mongolian Language Studies. Volume X. Lexicology, Semantics]. Ulaanbaatar: Soyombo printing. 2022.]
- Yuan Chao, Unenqi, Galsang, Hairhan.** (1992). *Монгол хэл шинжлэлийн толь*. Ляонингийн үндэстний хэвлэлийн хороо. [Yuan Chao, Unenqi, Galsang, Hairhan. *Mongol hel шинjleliin toli* [Linguistic dictionary of Mongolian language]. Liaoning traditional publishing. 1992.]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.